

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ИРГЭДИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хариуцлагын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн өмнө хүлээх хариуцлага					
	Даатгалын үндсэн эрсдэл	Даатгуулагч иргэний санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас бусдын 1. Амь нас, 2. Эрүүл мэнд 3. Эд хөрөнгөд учруулсан хохирол					
	Даатгалын нэмэлт эрсдэл	-					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	1.5-3.0%					

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

1. Даатгуулагчийн эзэмшсэн мэргэжил, хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээний дагуу гүйцэтгэж буй ажил үүрэгтэй холбогдон гарсан хариуцлагаас үүдэлтэй хохирол;
2. Даатгуулагчийн эзэмшиж, ашиглаж буй механик хөдөлгүүртэй бүх төрлийн тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдэлтэй аливаа хохирол;
3. Даатгуулагчийн хувийн эзэмшилд буй хөрөнгөндөө учруулсан хохирол;
4. Даатгуулагч өөрийн гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учруулсан хохирол;

5. Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна үүссэн хариуцлагаас үүдэлтэй хохирол;
6. Мэргэжлийн бус даатгуулагч нь мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцож байх үедээ бусдад учруулсан хохирол;
7. Даатгуулагчийн хууль бус санаатай үйлдлийн улмаас үүссэн хохирол;
8. Даатгагчийн зөвшөөрөлгүйгээр даатгуулагч нь аливаа нэхэмжлэлийг дур мэдэн шийдэх, санал гаргах, төлбөр төлөх эсвэл аливаа саналыг хүлээн зөвшөөрөх замаар өөрийн бурууг ямар нэгэн байдлаар хүлээсэн;
9. Даатгалын тохиолдол мөн эсэх нь нотлогдоогүй буюу нотлогдох боломжгүй болсон;
10. Даатгуулагч аюул ослын талаар даатгагч болон бусад холбогдох газруудад хугацаанд нь мэдэгдээгүй, аюул ослын талаар акт дүгнэлт хийлгээгүй;
11. Даатгуулагчийн санхүүгийн болон төлбөрийн чадвартай холбогдон гарсан аливаа хохирол;
12. Даатгуулагч согтууруулах мансууруулах бодис хэрэглэсэн үедээ бусдад учруулсан хохирол;
13. Даатгуулагчийн бусдад учруулсан хохирол нь бусад даатгалын гэрээгээр нөхөн төлөгдсөн;
14. Даатгуулагч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалан хохирол гарсан;
15. Даатгалын зүйлийн талаар хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, худал мэдээлэл өгсөн;
16. Ажил хаялт, нийгмийн замбараагүй байдал, иргэний бослого, үймээн, гэмт халдлага, террорист болог улс төрийн шинж чанартай үйл ажиллагааны улмаас үүдсэн хохирол;
17. Цөмийн шатахууны шатах процессоос гаралтай ямар нэгэн цөмийн хаягдал, цөмийн зэвсгийн материал, цөмийн шатахуунаас гарах радио идэвхит бохирдол, үүнээ үүсэх ионжсон цацраг зэргийн улмаас үүссэн хохирол;
18. Дайн, дайны шинжтэй тэмцэл, хувьсгал, маргаан, булаан эзлэх, барьцаалах, баривчлан саатуулах, мина хаях, бөмбөг дэлбэлэх зэрэг үйл ажиллагаанаас үүдсэн хохирол;
19. Хууль зөрчсөн үйл ажиллагаанаас үүдсэн хохирол, түүний үр дагавар;